



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 17 өдөр

Дугаар A/152

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.3 дахь заалт, 24.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/113 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1440 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотод 2025 оны 07 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд дуу цахилгаантай аадар бороо орж, хүчтэй салхи шуурсны улмаас аюулт үзэгдэлд өртсөн “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын хохирлыг арилгах үйл ажиллагааны зардлыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хавсралтад тусгасан үйл ажиллагааг Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллахыг Хотын тохижилтын хэлтэс (Б.Даваабаяр)-т, бий болсон хөрөнгийг холбогдох хууль, журамд заасны дагуу данс бүртгэлд тусган, Нийслэлийн өмчид бүртгүүлэхийг Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ (Д.Отгонбаатар)-т тус тус даалгасугай.

3. Дээрх ажилд шаардагдах 145,602,735 (нэг зуун дөчин таван сая зургаан зуун хоёр мянга долоон зуун гучин тав) төгрөгийн зардлыг тус албаны Хот тохижилтын бусад зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын газар (Г.Билгүүн)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА
Г.БАТЗОРИГ



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн
11/152 тушаалын хавсралт

АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН "МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН
ХОХИРЛЫГ АРИЛГАХ ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ ЗАРДАЛ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөвт өртөг /төгрөг/	Санхүүжих хугацаа
1	2	3	4
1	Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Хүй долоо худаг дахь "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын хохирлыг арилгах зардал	145,602,735	2025
Нийт		145,602,735	

[illegible]